

2023 оны 03 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар: 23/10

Улаанбаатар  
хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцааны үнэлгээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.6, 55.7 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлд хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий хараат бус үнэлгээний байгууллага болох “Хүлэгт Хүннү Аудит” ХХК-ийн 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Бизнесийн үнэлгээний тайланг үндэслэн, Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 9/979 дугаартай албан бичгээр ирүүлсэн шаардлагын дагуу “Хөвсгөл усан зам” ХК-ийн нэгж хувьцааны үнэлгээг 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс өмнөх сүүлийн 52 долоо хоногийн жигнэсэн дундаж ханшаар буюу 5,473 /таван мянга дөрвөн зуун далан гурав/ төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.
2. Тогтоолыг холбогдох журмын дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбатад үүрэг болгосугай.
3. Нэгж хувьцааны үнэлгээг шинэчлэн тогтоосон тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид хүргүүлж холбогдох зөвшөөрөл гаргуулах ажлыг хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Үржинбадамд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.ШАГДАРСҮРЭН